

ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ

ХИЛИЙН ЭРХ ЗҮЙ-ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЭРХ ЗҮЙН АРГА БОЛОХ НЬ

Г.Лхагвамаа.

Удирдлагын академийн АБУСПБ-ийн
профессор, доктор, дэд профессор

Товч агуулга. Хилийн аюулгүй байдлыг хангах цогц үйл ажиллагаанд эрх зүйн арга чухал байр суурийг эзэлнэ. Энэ нь эрх зүй гэсэн нийтлэг ойлголтоор бус Монгол Улсын үндэсний эрх зүйн тогтолцоо дахь бие даасан салбар эрх зүй болох хилийн эрх зүйн зорилго, чиг үүрэг дамжин хэрэгжинэ. Иймд энэхүү өгүүллээр хилийн эрх зүйн уламжлал, шинэчлэл, хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хилийн эрх зүйн гүйцэтгэх үүрэг зэрэг асуудалд судлаачдын анхаарлыг хандуулахыг зорилоо.

Түлхүүр үгс. Хилийн аюулгүй байдал, хангах арга, хилийн эрх зүй, уламжлал, шинэчлэл.

Оршил. Хилийн аюулгүй байдал улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн эрх бүхий байгууллагуудаас нэгдмэл бодлого, харилцан уялдаатай явуулах улс төр, эрх зүй, дипломат, эдийн засаг, байгаль орчин, тагнуул, улсын хил хамгаалалтын цогц үйл ажиллагаагаар хангагдах талаар төрөөс хилийн талаар баримтлах бодлогын баримт бичигт туссан. Эндээс хилийн аюулгүй байдлыг хангах цогц үйл ажиллагаанд эрх зүйн арга хэрэгсэл чухал болох нь харагддаг. Харин энэ асуудлыг хилийн болон аюулгүй байдал судлалд эрх зүй гэсэн ерөнхий байдлаар авч үзэж байгаа нь судалж байгаа асуудлыг ерөнхийлөх, хилийн эрх зүйн асуудлыг хууль зүйн шинжлэх ухааны үндэстэй шинжлэн

судлах боломжийг хязгаарлах талтай юм. Иймд хилийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн (арга) үйл ажиллагаа гэсэн нийтлэг ойлголтоор бус хилийн эрх зүйн хүрээнд авч үзэх асуудлыг судлаачийн хувьд анхлан дэвшүүлж байна.

Нэг. Хилийн эрх зүйн Үндсэн хуулийн үндэс, төрөөс хилийн талаар баримтлах бодлогын үзэл баримтлал. Аливаа салбар эрх зүйн харилцаа үүсэх эрх зүйн үндсийг Үндсэн хуулиар тодорхойлдог. Монгол Улсын Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна”, 2 дахь хэсэгт “Монгол улсын хилийг хуулиар бататгана” гэж заасан нь хилийн эрх зүйн харилцааны Үндсэн хуулийн үндэс мөн.

Түүнчлэн төрөөс хилийн талаар баримтлах баримт бичигт улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах механизмыг боловсронгуй болгох талаар 2.1 дэх хэсэгт “Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны зохицуулалт, уялдаа холбоог сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох”, 2.2-д “Хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх байгууллагыг эх оронч, мэдлэг, чадвартай боловсон хүчнээр хангана” гэж төрийн бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тусгасан байдаг.

Хилийн талаар баримтлах бодлогын баримт бичиг нь Үндсэн хуулийн үзэл баримтлалыг үндэслэн улсын хил, хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлын талаар Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрийн үндэс болсон залгамж чанартай тулгуур баримт бичиг юм.¹ Энэхүү чиглэлийг үндэс болгон Улсын Их Хурлаас 2016 онд Монгол Улсын хилийн тухай хуулийг шинэчлэн найруулж баталжээ.

Монгол Улсын хилийн тухай хуулийн 5.1 дэх хэсэгт “Монгол Улсын хилийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг мөн.”, 5.2 дахь хэсэгт “Хилийн аюулгүй байдал гэж улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл

баталгаатай хангагдсаныг хэлнэ”, 5.3 дахь хэсэгт “Хилийн аюулгүй байдал нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн эрх бүхий байгууллагуудаас нэгдмэл бодлого, харилцан уялдаатай явуулах улс төр, эрх зүй, дипломат, эдийн засаг, байгаль орчин, тагнуул, улсын хил хамгаалалтын цогц үйл ажиллагаагаар хангагдана” гэж тус тус заасан. Эдгээр заалт хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоонд эрх зүйн арга хэрэгсэл чухал болохыг тодорхойлсон үндэслэл юм. Энэ нь хилийн эрх зүйн зорилго, чиг үүргээр дамжин хэрэгжих учиртай. Иймд хилийн эрх зүйн онол, арга зүйн үндсийг эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн хилийн эрх зүйд шинэлэг байдлаар хандах, судалж, хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг нөхцөлдүүлж байна.

Хоёр. Хилийн тухай хууль-хилийн аюулгүй байдлыг хангах хилийн эрх зүйн гол эх сурвалж болох нь. Хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндэсний эрх зүйн зохицуулалтад Монгол Улсын Үндсэн хууль, Хилийн тухай хууль, Улсын хилийг хамтран шалгахад баримтлах чиглэлийн тухай², Монгол Улсын хилийг шалгасан баримт бичиг батлах тухай хууль болон хилийн эрх зүйн хэм хэмжээг

¹ “Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”. УИХ-ын 2002 оны 20 дугаар тогтоолын хавсралт.

² Улсын хилийг хамтран шалгахад баримтлах чиглэлийн тухай хууль” Төрийн мэдээлэл. 1993. № 4-5.

агуулсан бусад хууль тотоомжууд нэгэн адил хамаарна.¹

Хүснэгт 1. Хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт

№	Эрх зүйн актын төрөл	Тоо хэмжээ
1.	Хууль	70
2.	Ерөнхийлөгчийн зарлиг	3
3.	УИХ-ын тогтоол	2
4.	Засгийн газрын тогтоол	4
5.	ХЗДХ-ийн сайдын тушаал	8
6.	Хамтарсан тушаал	1
7.	ХХЕГ-ын даргын тушаал /2017 /	64
	Нийт	152

Эх сурвалж: “Хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн орчин”. ДХИС,ХХЕГ-ын хамтарсан төсөлт судалгааны ажил. 2018.

Энэхүү өгүүллээр хилийн эрх зүйн гол эх сурвалж болох хилийн тухай хуулийг хөндөж байгааг тэмдэглэж байна.

Хилийн тухай хуулийн уламжлал, шинэтгэл

БНМАУ-ын Засгийн газрын 27 дугаар хурлаар 1928 оны 9 дүгээр сарын 24-нд харуулын цагдаа нарын үүрэг хариуцлагыг тодорхойлсон дүрэм баталж, уг дүрэмд улсын хил хамгаалах арга ажиллагаа, хилийн журам дэглэмийг сахиулах талаар тодорхой заасан байна.²

Дотоод явдлын яамны сайдын 1943 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 84 тоот тушаалаар батлагдсан “БНМАУ-ын хил хамгаалалтын албаны дүрэм” нь хязгаарын цэргийн эрх, үүрэг гүйцэтгэх журам, арга ажиллагааг

тодорхойлсон анхны чухал баримт бичиг юм.³

Өмнөх нийгмийн тогтолцоонд хилийн эрх зүйн харилцаа 1970 оныг хүртэл НАХЯ, ХЦУГ-ын тусгай дүрэм журам, заавраар зохицуулагдаж байсныг улсын хил, хилийн харилцаа, хил хамгаалах байгууллагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилт болон хилийн асуудлыг тусгайлсан хуулиар зохицуулах бодит шаардлагыг харгалзан БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1973 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 161 дүгээр зарлигаар анхны “БНМАУ-ын Хил Хамгаалах хууль”-ийг батлан мөрдүүлж байжээ. Уг хууль нь Монгол улсын хилийн харилцаатай холбоотой асуудлыг зохицуулах эрх зүйн шинэ орчин бүрдүүлснээрээ чухал ач холбогдолтой байсан.⁴

¹ Хилийн эрх зүйн бусад эх сурвалжыг “Хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн орчин”. ДХИС,ХХЕГ-ын хамтарсан төсөлт судалгааны ажил. 2018. үзнэ үү.

² Лувсан. Ч, Дашням. Ж, нар. Хилчний сурах бичиг. Уб., 1978. 22 дахь тал.

³ “Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хүрээнд хийсэн судалгаа” Судалгааны тайлангийн эмхэтгэл /2010-2012/. Хууль зүйн үндэсний хүрээлэн. УБ., 2012. 114 дэх тал

⁴ Базарсад. Д, Улсын хилийн албаны эрх зүйн асуудлууд. Уб., 1995.

1973 оны БНМАУ-ын Хил Хамгаалах хуульд улсын хилийн тухай нийтлэг үндэслэл, хилийг хамгаалах асуудал тодорхой зааг ялгаагүй тусгагдаж, улсын хилийн дэглэм гэсэн зүйлд хил залгаа улстай хилийн асуудлаар харилцан тохирсон дэглэмийн асуудлыг хилийн журамтай хамтатган зааж, хилийн дэглэмээ хүндэтгэн сахиулахад хил орчмын нутаг дэвсгэрт мөрдөх журам тогтоож тэр нь дэглэмдээ үйлчилж байдгийг тодорхой заагаагүйгээс хоёр өөр асуудлыг хутган ойлгоход хүргэж, улсын хил хамгаалах журамд зөвхөн хилийн цэргийн эрх, үүргийг тодорхойлсноор ард иргэдийн үүрэг оролцоог орхигдуулсан, түүнчлэн хилийн хууль тогтоомж зөрчсөн хүмүүст хариуцлага тооцох зэрэг асуудлыг төдий л оновчтой тусгаагүй байжээ.¹ Энэ хуулийг МУ-ын Хилийн тухай 1993 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн хууль батлагдсанаар хүчингүй болгосон.

1973 оны БНМАУ-ын Хил хамгаалах хууль БНМАУ-ын хил хамгаалалтын зорилго, улсын хил тогтоох, хамгаалах зарчим, хилийн журам, чухам ямар үйлдлийг хилийн зөрчилд тооцох зэргийг тодорхойлон хязгаарын цэргийн эрх, үүргийг тогтоосон бол 1993 оны Хилийн тухай хууль 1992 оны Үндсэн хуульд “Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна”. “Улсын

хилийг хуулиар бататгана” гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд чиглэгдэгдсэн органик хууль² бөгөөд тухайн үеийн нийгэм, эдийн засгийн тогтолцооны өөрчлөлттэй уялдсан байжээ.

Монгол Улсын хилийн тухай хууль 1993 онд батлагдсанаас хойш уг хуульд улсын хилийн хамгаалалт, улсын хилээр зорчигч тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, хил хамгаалах байгууллагад үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хүрээнд 13 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.³

Улсын хилийн аюулгүй байдлыг хангах хүрээнд хилийн болон хил орчмын дэглэм, хилийн боомт түүнд мөрдөх журмын зохицуулалтыг боловсронгуй болгох, хилийн нөхцөл байдал, хүрээлэн байгаа орчин, газар зүйн онцлогт тохируулсан улсын хил хамгаалалтыг бүсчилэн зохион байгуулах, хилийн аюулгүй байдлыг хангах төрийн байгууллагын тогтолцоо, хилчдийн эрх зүйн байдал, улсын хил хамгаалалтад иргэн, байгууллагуудын оролцоог шинэчлэн тодорхойлох, уг хуулийн зарим нэр томъёог олон улсын эрх зүйн зарчим, олон улсын гэрээ, хэлэлцээр болон 2010 онд Улсын Их хурлаас баталсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д нийцүүлэх зэрэг хэрэгцээ шаардлагаар шинэчлэн найруулсан Монгол Улсын хилийн

¹ “Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хүрээнд хийсэн судалгаа” Судалгааны тайлангийн эмхэтгэл /2010-2012/. Хууль зүйн үндэсний хүрээлэн. УБ., 2012. 115 дахь тал

² Органик хууль бол Үндсэн хуулинд тухайлан заасан заалтад үндэслэн

түүнийг шууд хэрэгжүүлэх замаар гарсан хууль юм. Эндээс үзэхэд Монгол Улсын Хилийн тухай хууль нь органик хуулийн шинжийг бүрэн агуулж байна.

³ “Хуульч news” сэтгүүл 2016. 12 дугаар сар. №13 (14).

тухай хуулийг УИХ-аас 2016 онд баталж, 2017 оны 2 дугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн.

Хилийн аюулгүй байдлыг хангах гол эх сурвалж бол 2016 оны 12 дугаар сарын 28-ний өдөр УИХ-аас батлагдсан Монгол Улсын хилийн тухай хууль мөн.

Хилийн тухай хуулийн 1.1 дэх хэсэгт Монгол Улсын хилийн халдашгүй, дархан байдлыг хангах зорилгоор хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, улсын хил хамгаалах байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, бүрэн эрх, улсын хил хамгаалалтад иргэн, байгууллагын оролцоог тодорхойлж, хилийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон бусад харилцааг зохицуулахад энэ хуулийн зорилт оршино гэж заасан нь энэ хуулийн бүтэц, агуулгыг илэрхийлнэ. Тухайлбал, 1) Нийтлэг үндэслэлд хилийн тухай хуулийн зорилт, Монгол Улсын хилийн хууль тогтоомж, хуулийн нэр томъёоны тодорхойлолт, Монгол Улсын хил, Монгол Улсын хилийн аюулгүй байдал, Улсын хилийн шугамын асуудлыг шийдвэрлэх, улсын хилийг тодорхойлох, улсын хилийг тогтоох, улсын хилийг тэмдэглэх, улсын хилийг хамтран шалгах, Монгол Улсын хилийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт. 2) Улсын хилийн дэглэм, түүний зорилго, агуулга, улсын хилийн дэглэмийг тогтоох, улсын хилийг арчлан хамгаалах, улсын хилээр зорчигч тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх, улсын хилийн боомт дээр ажиллах

хяналт шалгалтын байгууллага, хилийн ус, улсын хилийн дамнасан байгууламжийг ашиглах, улсын хил дээр ан агнуур, ажил, үйлдвэрлэл явуулах, улсын хил орчмын нутаг дэвсгэрийн байгаль орчин, амьтныг хамгаалах, хилийн зөрчил, Монгол Улсын хилийн төлөөлөгч 3) Улсын хил орчмын дэглэм, зорилго, агуулга, улсын хилийн зурвас, хилийн боомтын төрөл, горим, зэрэглэл, хилийн боомтын удирдлага, улсын хилийн бүс, тэдгээрт мөрдөх журам 4) Улсын хил хамгаалалт, зарчим, бүсчилсэн хил хамгаалалт, Улсын хил хамгаалах байгууллага, түүний тогтолцоо, чиг үүрэг, бүрэн эрх, хилчний алба, цол, дүрэмт хувцас, хилчин улсын хилд албан үүрэг гүйцэтгэж байгаа иргэний эрх зүйн баталгаа 5) Биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх үндэслэл, албаны нохой ашиглах 6) Улсын хилийн аюулгүй байдлыг хангахад төрийн болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтны эрх, үүрэг 7) Улсын хил хамгаалахад туслах хүчний оролцоо, туслах хүчний удирдлага, зөвлөлийн болон туслах гишүүний эрх, үүрэг, Монгол Улсын иргэний эрх, үүрэг 8) Бусад зүйл буюу хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацаа гэсэн бүтэцтэй.

Дээрх бүтцээс харахад хилийн аюулгүй байдлыг хангах, хил хамгаалах байгууллагын бүтэц, тогтолцоо, чиг үүрэг, улсын хил хамгаалалт зэрэг бүхий л харилцааг зохицуулж, хамгаалахад хилийн тухай хууль нь хилийн эрх зүйн гол эх сурвалж болохыг харуулж байна.

Уг хууль батлагдан хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш

2021, 2023 онд хилийн мэргэжлийн хяналтын байгууллага, хилийн боомтын захиргааны үйл ажиллагааг хуульчлан зохицуулах болон төр, хувийн хэвшлийн түншлэл, зөвшөөрлийн тухай хуулиуд батлагдсан зэрэгтэй холбогдуулан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байна. Гэхдээ эрх зүйн зохицуулалт бүрэн шинэчлэгдсэн гэж дүгнэж болохгүй. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудал нь тасралтгүй хэрэгжих байнгын үйл явц бөгөөд энэ асуудал нь зөвхөн хууль тогтоомжийг шинээр батлах, тэдгээрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулах төдий асуудал биш нэгэнт батлагдсан хуулийн амьдралд хэрэгжүүлэх, хууль амьдралын холбоо, хуулиудын хоорондын уялдаа холбоог хангах явдал билээ¹.

Иймд хилийн аюулгүй байдлыг хангах хилийн эрх зүйн хэрэгжилтэд тулгамдсан асуудалд хуульзүйн дүн шинжилгээ хийх, шийдвэрлэх арга замыг тодорхойлох зэрэгт эрх зүйн болон хил судлалын судлаач эрдэмтдийг татан оролцуулах замаар судалгааг өргөжүүлэх шаардлага бидний өмнө тавигдаж байна.

Гурав. Хилийн эрх зүйн онцлог. Улсын хилийн өөрийн аюулгүй байдал олон улсын эрх зүйгээр баталгааждаг бол харин хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал Монгол Улсын хууль, эрх зүйгээр зохицолддог онцлогтой.² гэж

академич Ш.Арвай судалгааны ажилд тэмдэглэсэн байдаг.

Хилийн эрх зүйн хамгийн анхны эрх зүйн эх сурвалж бол 1689 онд Хаант Орос улс болон Манж Чин улсын хооронд байгуулсан түүхэнд “Нэрчүгийн гэрээ” гэж нэрлэгдсэн хилийн гэрээ гэж судлаачид дүгнэдэг. Түүний дараа 1727 оны Буурын голын хилийн гэрээ, 1728 оны Хиагтын гэрээ, 1864 оны Тарвагатай хотын хилийн протокол зэрэг Монгол улсын хилийг тодорхойлж, тогтоож тэмдэглэсэн түүхэн гэрээ, хэлэлцээр, протоколуудыг нэрлэж болно.

Хилийн эрх зүйн зохицуулалтад Монгол Улсын нэгдэн орж соёрхон баталсан “НҮБ-ын дүрэм”, 1958 оны БНМАУ, ЗСБНХУ-ын Хилийн тухай гэрээ, 1962 оны “БНМАУ, БНХАУ-ын Хилийн гэрээ”, 1976 оны “БНМАУ, ЗСБНХУ-ын Хилийн гэрээ”, “Монгол-Оросын хилийн дэглэмийн тухай Монгол улс, Оросын Холбооны Улс хоорондын 2006 оны гэрээ, Монгол-Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол улс, БНХАУ-ын хоорондын 2010 оны гэрээ, “Гурван улсын хилийн уулзваруудын цэгийг тодорхойлох Монгол, Орос, Хятад Улсын Засгийн газар хоорондын 1994 оны хэлэлцээр зэрэг Олон улсын гэрээ, конвенциуд чухал үүрэг гүйцэтгэнэ. Тухайлбал, Олон улсын эрх зүйн тулгуур баримт бичиг болох НҮБ-ын дүрмийн 1 дүгээр бүлгийн 4-т “НҮБ-ын бүх гишүүн нь олон улсын харилцаандаа

¹ Лхагвамаа. Г, “Хилийн эрх зүйн онол, практикийн тулгамдсан асуудал” Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 2018. 257 дахь тал.

² Арвай. Ш, Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам. “Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам”. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 2018. 23 дахь тал.

аливаа улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал буюу улс төрийн тусгаар тогтнолын эсрэг хүчээр сүрдүүлэх болон хүч хэрэглэх, түүнчлэн НҮБ-ын зорилгод харшлах ямарваа үйлдэл хийхийг хориглоно” гэж гишүүн орнуудын хилийн халдашгүй дархан байдлыг баталгаажуулжээ.

Хилийн эрх зүйн харилцаанд баримтлах олон улсын эрх зүйн зарчим

НҮБ-ын дүрмийн дагуу улс орнуудын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх олон улсын эрх зүйн зарчмын тухай Тунхаглалыг 1970 оны 10 дугаар сарын 24-ний өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас, оролцогч улс хоорондын харилцаанд зайлшгүй баримтлах зарчмын Тунхаглалыг 1975 оны 8 дугаар сарын 1-ний өдөр Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны төгсгөлийн актаар тус тус баталсан байна.

Дээрх баримт бичгүүдэд олон улсын эрх зүйн үндсэн зарчмуудыг дараах байдлаар баталгаажуулсан байна. Үүнд:

- улсын хил халдашгүй дархан байх;
- нутаг дэвсгэр бүрэн бүтэн байх;
- хүч үл хэрэглэх, хүчээр үл заналхийлэх;
- маргааныг эв зүйгээр шийдвэрлэх;
- дотоодын хэрэгт үл оролцох;
- улс гүрний тэгш бүрэн эрхийн;
- хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн дээдлэх;
- улс гүрэн бүр заавал хамтран ажиллах;

- ард түмнүүд тэгш эрхээр өөртөө засан тогтнох;

олон улсын гэрээнд заасан үүргээ шударгаар биелүүлэх.

Түүнчлэн хилийн зөрчилтэй холбоотой асуудал ч олон улсын эрх зүйн эх сурвалж, гэрээ хэлэлцээрээр зохицуулагдаж, шийдвэрлэгддэг нь энэхүү салбар эрх зүйн онцлог юм.

Дүгнэлт

Хилийн эрх зүй бол Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн үндэс суурь мөн.

Хилийн эрх зүйг хөгжүүлэх нь Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн үндэс суурийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн үндсийг Монгол Улсын Үндсэн хууль, Хилийн тухай хуулиас гадна холбогдох бусад хууль тогтоомжоор тодорхойлох бөгөөд хилийн эрх зүйн зохицуулалтад үндэсний болон олон улсын эрх зүйн эх сурвалжууд ч онцгой үүрэг гүйцэтгэж байгаа нь уг салбар эрх зүйн онцлогыг нээн харуулж байна.

Санал

Хилийн аюулгүй байдлыг хангах цогц үйл ажиллагаанд “Эрх зүй”-н үйл ажиллагаа (арга) гэж хэт ерөнхийлсэн байдлаар тодорхойлсныг цаашид “Хилийн эрх зүй”-н хүрээнд авч үзэх асуудлыг судлаачийн хувьд дэвшүүлж байна. Үүний тулд хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн үндэс, зохицуулалтыг хилийн эрх зүйн үүднээс авч үзэж, цаашлаад хилийн эрх зүйн аливаа асуудлыг эрх

зүйн онолын эш үндэслэлтэйгээр судлах, боловсронгуй болгох шаардлагатай юм.

Эх сурвалжийн жагсаалт

1. “Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”. УИХ-ын 2002 оны 20 дугаар тогтоолын хавсралт.
2. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл. 1992. № 1
3. Монгол Улсын Хилийн тухай хууль. Төрийн мэдээлэл. 2017. №6
4. “Улсын хилийг хамтран шалгахад баримтлах чиглэлийн тухай хууль” Төрийн мэдээлэл. 1993. № 4-5.
5. Жанцан С. Хилийн аюулгүй байдлын эрх зүйн орчин, түүнийг боловсронгуй болгох асуудал”. “Улсын хилийн аюулгүй байдал ба хамтын ажиллагаа” олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2012.
6. Лувсан Ч, Дашням Ж. “Хилчний сурах бичиг” УБ., 1978.
7. Лхагвамаа Г, Мягмарбаяр Ч, Хилийн эрх зүй. УБ., 2019.
8. “Хилийн аюулгүй байдал ба эрх зүйн орчин”. ДХИС,ХХЕГ-ын хамтарсан төсөлт судалгааны ажил.
9. “Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хүрээнд хийсэн судалгаа” Судалгааны тайлангийн эмхэтгэл /2010-2012/. Хууль зүйн үндэсний хүрээлэн. УБ., 2012.
10. “Хуульч news” сэтгүүл 2016. №13 (14).